



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

ХУВИЙН ХЭВШИЛД ЗОРИУЛСАН

Авлигаас Урьдчилан Сэргийлэх

Зөвлөмж

УЛААНБААТАР ХОТ

Шударга ёс, жөгжил дэвшилд



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

Шударга ёс, хөгжил дэвшилд

Боловсруулсан:

Д.Цэнд-Аюуш

*АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх
хэлтсийн ахлах ажилтан*

А.Баянмөнх

Азийн сангийн Засаглалын хөтөлбөрийн менежер

Хянасан:

Д.Дуламсүрэн

*АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх
хэлтсийн дарга*

Гарын авлагатай холбоотой санал хүсэлтээ дараахь хаягаар ирүүлнэ үү.

Авлигатай тэмцэх газар

Утас: 70112474

Цахим шуудан: hutulbur@iaac.mn

Цаасны хэмжээ: 213x216

Хэвлэсэн тоо: 3000

“УРАНГАР ПРЕСС” ХХК-д хэвлэв.

2019 он



АГУУЛГА

- Зөвлөмж 1.** Авлига гэж юу вэ? 8
- Зөвлөмж 2.** Авлигын эсрэг хууль тогтоомжийн үйлчлэлд хэн хамаардаг вэ? 11
- Зөвлөмж 3.** Нийтийн албан тушаалтанд тавигддаг хориглолт, хязгаарлалтыг мэдэх үү? 13
- Зөвлөмж 4.** Хээл хахууль өгөхөөр амласан, санал болгосон тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульд өөрчлөлт орсныг сонссон уу? 19
- Зөвлөмж 5.** Хээл хахууль авах гэмт хэрэгт хувийн хэвшлийн ажилтан хариуцлага хүлээлгэх хуультай болсныг мэдсэн үү? 21
- Зөвлөмж 6.** Танай компани авлигын эсрэг баримтлах бодлого, зарчмаа тодорхойлсон уу? 23
- Зөвлөмж 7.** Танай компани дотоод хяналтын тогтолцоотой юу? 25
- Зөвлөмж 8.** Танай байгууллага үйл ажиллагаандаа мөрдөх ёс зүйн зарчим, дүрэмтэй юу? 27
- Зөвлөмж 9.** Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авдаг уу? 30

БИЗНЕС ЭРХЛЭГЧ ТАНАА

Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд хувийн хэвшлийн оролцоо, хамтын ажиллагаа чухал болохыг Авлигын эсрэг НҮБ-ын конвенцид онцолж, гишүүн улс бүр хувийн хэвшилд авлигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахыг үүрэг болгосон байдаг. Түүнчлэн Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт хувийн хэвшил дэх авлигын эрсдэлийг бууруулах, өрсөлдөөний шударга байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх зорилтыг дэвшүүлсэн юм.

Хэдийгээр Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй авлигын эсрэг хууль тогтоомж үндсэндээ төрийн албан хаагчид хамаарч байгаа хэдий ч хуулийн заалтууд нь шууд бус байдлаар бизнес эрхлэгч, хуулийн этгээдэд хамааралтай, тэдний эрх, ашиг сонирхлыг хөндөж байдаг.

Авлигын асуудал нь зөвхөн төрийн байгууллага, албан тушаалтантай харилцахад хувийн хэвшлийн хувьд яригддаг байсан бол өдгөө бизнесийн байгууллагын дотор болон хувийн хэвшлийн байгууллага хоорондын харилцаанд авлигын эрсдэл үүсдэг болжээ. Аливаа компани, түүний аль нэг ажилтны хууль бус ганцхан үйлдэл тухайн бизнесийг бүхэлд нь эрсдэлд

оруулах үр дагавартай учраас тэдгээрээс урьдчилан сэргийлэх нь чухал юм.

Бизнес эрхлэгчид нэг талаас авлигын хохирогч, хүлцэн тэвчигч, нөгөө талаас хахуульдагч байх тохиолдол олон. Тиймээс авлигын эрсдэлээс өөрийгөө болон бизнесээ хамгаалахын тулд хууль тогтоомжийн холбогдох зохицуулалтыг судалж ойлгох, танд хэрхэн хамаарч болох талаар мэдэх хэрэгтэй.

Монгол Улсад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх асуудлыг 2006 онд шинэчлэн баталсан Монгол Улсын Авлигын эсрэг хууль, 2012 онд баталсан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, 2017 онд шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн Авлигын гэмт хэрэг бүлгээр тус тус нарийвчлан зохицуулдаг. Ялангуяа, 2017 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг хуульчилж,



мөн авлигын гэмт хэргийг хэлбэрийн бүрэлдэхүүнтэй болгосон буюу материаллаг хохирол шаардахгүй, өөртөө болон бусдад давуу байдал олгосноор гэмт хэрэг гэж тооцохоор өөрчилсөн нь хувийн хэвшлийнхэн зайлшгүй уншиж судлах шаардлагыг бий болгож байгаа юм.

Иймд авлигын эсрэг хууль тогтоомжоос бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаандаа анхаарвал зохих зохицуулалт, мөн бизнесийн байгууллагууд авч хэрэгжүүлбэл зохих есөн зөвлөмжийг энэхүү товч гарын авлагад багтаав.

9

ХУВИЙН ХЭВШЛИЙН БАЙГУУЛЛАГАД ЗОРИУЛСАН АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗӨВЛӨМЖ

ЗӨВЛӨМЖ 1. Авлига нь зөвхөн хээл хахуулийн хэлбэрээр илэрдэггүй, тиймээс бусад хэлбэрийг таньж мэдэхийн тулд хуулийн холбогдох нэр томъёог сайтар судалж ойлгох нь чухал.

ЗӨВЛӨМЖ 2. Авлигын эсрэг хууль тогтоомжийн үйлчлэлд төрийн бүх албан тушаалтан хамаардаггүй. Тиймээс төрийн аль байгууллага, ямар албан тушаалтантай харилцахдаа авлигын эсрэг хууль тогтоомжийн үйлчлэлд хамаарах эсэх, хамтран ажиллахад анхаарах зүйлийг мэдэж байх шаардлагатай.

ЗӨВЛӨМЖ 3. Төрийн байгууллага, албан тушаалтантай харилцахад тэдэнд юуг хориглодог, ямар үйлдэл, үйл ажиллагааг хязгаарладгийг мэдсэн байх нь аливаа хууль бус асуудалд холбогдохоос урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

ЗӨВЛӨМЖ 4. Нийтийн албан тушаалтанд хууль бус хүсэлт тавих, зохисгүй нөлөөлөл үзүүлэх, хээл хахууль санал болгох нь Танай байгууллагад хариуцлага хүлээлгэх үндэслэл болно. Иймд бизнесийн үйл ажиллагаандаа зохисгүй харилцаа үүсгэхгүй байх талаар ажилтнууддаа зааж зөвлөж байх хэрэгтэй.

ЗӨВЛӨМЖ 5. Хээл хахууль авах гэмт хэрэг нь зөвхөн нийтийн албан тушаалтанд хамаарч байсан бол хувийн хэвшлийн байгууллагын ажилтанд ч мөн хамаарах болсон. Өөрөөр хэлбэл ажил, үүргээ хэрэгжүүлсний хариуд, эсхүл хэрэгжүүлэхийн тулд шууд, эсхүл бусдаар дамжуулан хахууль өгөхийг шаардсан, авсан бол авлигын хэрэгт шалгагдахаар болсныг Танай компанийн ажилтнууд ойлгож, мэдсэн болов уу? Ажилтнуудаа чадавхжуулах, сургалтын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх нь болзошгүй эрсдэлээс хамгаална.


ЗӨВЛӨМЖ 6. Аль нэг ажилтны тань “болгоомжгүй” үйлдэл танай нийт бизнесийн үйл ажиллагааг эрсдэлд оруулж болзошгүй тул авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулж, компанийн удирдлагаас авлигын эсрэг баримтлах бодлого, байр суурийг танилцуулж, ажилтнууд ажил үүргээ гүйцэтгэхдээ мөрдөх ёс зүйн зарчим, хүлээлгэх хариуцлагыг тодорхой, ойлгомжтой болгож өгөх нь чухал.

ЗӨВЛӨМЖ 7. Хуулийн этгээдийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтан хувьдаа, бусдад

давуу байдал тогтоох, ашиг хонжоо олох зорилгоор албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласан нь компанид хохирол учруулсан бол авлигын хэрэгт хариуцлага хүлээх үндэслэл болохоор хуульд өөрчлөлт орсон. Тийм учраас компанийн засаглалыг сайжруулж, дотоод хяналтын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх хэрэгтэй.

ЗӨВЛӨМЖ 8. Бизнесийн үйл ажиллагаанд бусад байгууллага, аж ахуйн нэгж, туслан гүйцэтгэгчидтэй харилцах, гэрээ хэлэлцээр байгуулахдаа баримтлах ёс зүйн дүрмийг тогтоон хэрэгжүүлэх, мөн уг асуудлаар мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах, зөвлөгөө, мэдээлэл авч байх нь үр дүнтэй.

ЗӨВЛӨМЖ 9. Авлигын аливаа тохиолдлыг мэдээлж хэвших нь чухал, түүнчлэн авлигыг үүсгэж буй төрийн байгууллагын хүнд суртал, чирэгдэл, хууль бус дүрэм журмыг өөрчлөх талаар Авлигатай тэмцэх байгууллагад хандаж хамтран ажиллахыг зөвлөж байна.



ЗӨВЛӨМЖ

1

Авлига нь зөвхөн хээл хахуулийн хэлбэрээр илэрдэггүй, тиймээс бусад хэлбэрийг таньж мэдэхийн тулд хуулийн холбогдох нэр томъёог судалж ойлгох нь чухал.

Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг нийтийн албан тушаалтнууд сахин биелүүлж, дагаж мөрддөг.

Харин эдгээр хуулийн зохицуулалт, хориглолт хязгаарлалтыг бизнес эрхлэгч, хувийн хэвшлийн байгууллага мэдэж байх нь авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхад тустай. Иймд дээрх хууль тогтоомжид тодорхойлсон зарим нэр томъёотой танилцъя.



АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛИЙН 3 ДУГААР ЗҮЙЛ

Эдгээр нэр томъёог дараахь утгаар ойлгоно:

1. “авлига” гэж Авлигын эсрэг хуульд заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг;
2. “ашиг хонжоо” гэж Авлигын эсрэг хуульд заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглаж бусдад давуу байдал олгосны төлөө өөрт нь болон бусдад буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг;
3. “албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах” гэж албан тушаалын эрх мэдлийг албаны эрх ашгийн эсрэг буюу хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдэл хийхийг;
4. “давуу байдал” гэж Авлигын эсрэг хуульд заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласнаар хувь хүн, хуулийн этгээдэд буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг;

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт



Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1. “нийтийн ашиг сонирхол” гэж нийтийн албан тушаалтан Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар олгогдсон бүрэн эрхээ хувийн ашиг сонирхлоосоо ангид тэгш, шударгаар хэрэгжүүлнэ гэх олон нийтийн итгэлийг;
2. “хувийн ашиг сонирхол” гэж нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөлж болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг;
3. “ашиг сонирхлын зөрчил” гэж нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэх үед түүний хувийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх болон албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдлыг;
4. “нийтийн албан тушаалтан” гэж Авлигын эсрэг хуульд заасан этгээдийг;
5. “хамаарал бүхий этгээд” гэж тухайн нийтийн албан тушаалтны эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдийг;
6. “нэгдмэл сонирхолтой этгээд” гэж тухайн нийтийн албан тушаалтантай ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийг;

7. “ашгийн төлөө үйл ажиллагаа” гэж компани, нөхөрлөл, хувиараа эрхлэх аж ахуй зэрэг аж ахуй, худалдаа, зээл, санхүүгийн бүх төрлийн байгууллагын үйл ажиллагааг;
8. “хандив” гэж нийтийн албан тушаалтанд тодорхой зориулалтаар, үнэ төлбөргүй, эсхүл нийтэд санал болгож байгаа хөнгөлөлтөөс илүү хөнгөлөлттэй үнээр санхүүгийн эх үүсвэр, эд хөрөнгө шилжүүлэх болон үйлчилгээ үзүүлэхийг;
9. “бэлэг” гэж нийтийн албан тушаалтанд үнэ төлбөргүй эд хөрөнгө өгөх, үйлчилгээ үзүүлэх болон эрх шилжүүлэх, үүргээс чөлөөлөх, нийтийн албан тушаалтантай хамаарал бүхий этгээдийн тусын тулд эрхээс

татгалзах зэрэг бусад хэлбэрийн санхүүгийн үр ашгийг;

10. “бүтээлч ажил” гэж төлбөр, орлого олж байгаа сэтгүүл зүй, утга зохиолын болон урлагийн бүтээлийг.
11. “ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал” гэж тухайн нийтийн албан тушаалтан өөрийн нэг ангид сурч байсан болон сурч байгаа этгээд, мөн гишүүнчлэлд нь хамаардаг холбоо, сан, хамтын шийдвэр гаргадаг байгууллага, тэдгээрийн гишүүд, нэг нутгийн хүн гэх зэрэг олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгохуйц этгээдтэй холбоотой асуудлаар үйл ажиллагаа явуулахыг ойлгоно.



ЗӨВЛӨМЖ

2

Авлигын эсрэг хууль тогтоомжийн үйлчлэлд төрийн бүх албан тушаалтан хамаардаггүй. Тиймээс төрийн аль байгууллага, ямар албан тушаалтантай харилцахдаа авлигын эсрэг хууль тогтоомжийн үйлчлэлд хамаарах эсэх, хамтран ажиллахад анхаарах зүйлийг мэдэж байх шаарлагатай.



Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн үйлчлэлд төрийн дараахь албан тушаалтан хамаарах бөгөөд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тодорхой хориглолт, хязгаарлалтыг мөрдөж үүргийг хүлээж байдаг. Тиймээс таны бизнесийн үйл ажиллагааны явцад дараахь албан тушаалтнуудтай харилцахдаа хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг мэдэж байх, зөрчиж байгааг мэдсэн бол холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдэгдэж зөрчлийг таслан зогсоож байх нь чухал юм.

АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛИЙН 4 ДҮГЭЭР ЗҮЙЛ

Хуулийн үйлчлэлд хамаарах этгээд

4.1. Доор дурдсан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарна:

4.1.1. төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан;

4.1.2. төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан болон ерөнхий нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч;

4.1.3. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан;

4.1.4. олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал;

4.1.5. улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан;

4.1.6. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч;

4.1.7. бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч;

4.1.8. эрх бүхий байгууллагаас баталсан жагсаалтад заасан албан тушаалтан.

4.1.9. Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 4.1.7-д заасан Ирээдүйн өв сан корпорацийн эрх бүхий албан тушаалтан, хяналтын зөвлөлийн гишүүн.

Дээрх албан тушаалтнуудад нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай **хуулийн үйлчлэлд нэгэн адил** хамаарна.



ЗӨВЛӨМЖ

3

Төрийн байгууллага, албан тушаалтантай харилцахад тэдэнд юуг хориглодог, ямар үйлдэл, үйл ажиллагааг хязгаарладгийг мэдсэн байх нь аливаа хууль бус асуудалд холбогдохоос урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйл, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйл, мөн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар дээрх албан тушаалтнуудад тодорхой хориглолт, хязгаарлалтыг тогтоож өгчээ. Төрийн албан хаагч, нийтийн албан тушаалтанд тавигддаг хориглолт, хязгаарлалт нь тэдгээрийг албан үүргээ гүйцэтгэхдээ бусдаас аливаа хууль бус зүйл шаардах, ажил албанаасаа ашиг хонжоо хайх, эрх мэдлээ урвуулан ашиглахаас сэргийлж, төрийн байгууллага, албан тушаалтантай харилцаж буй **иргэн, хуулийн этгээдийн эрх ашгийг хамгаалах** ач холбогдолтой.

Тухайлбал, Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэсний төлөө аливаа төлбөр (шан харамж) авах, мөн албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан бусдаас **бэлэг** шууд буюу шууд бусаар авахыг хориглоно. Түүнчлэн төрийн байгууллага, албан тушаалтнаас нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс **бэлэг, бусад санхүүгийн туслалцаа (хандив)-г авах, хүсэхийг хориглодог.**

Иймд бизнесийн үйл ажиллагаанд төрийн байгууллага, албан тушаалтантай харилцахад эдгээр зохицуулалтыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйд ямар нэг байдлаар холбогдохгүй байхаас гадна тэдгээрийг хэрхэн мөрдөж байгаад хяналт тавьж байх нь авлигын гэмт хэрэг, зөрчлийн эрсдэлээс танай байгууллагыг урьдчилан сэргийлнэ.

АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛИЙН 7 ДУГААР ЗҮЙЛ

Хориглох зүйл

7.1. Энэ хуулийн 4.1-д заасан этгээдэд бусад хууль тогтоомжид тусгайлан хориглосноос гадна **авлигын дараахь зөрчлийг хориглоно:**

- 7.1.1 албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид дарамт, шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх;
- 7.1.2 бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах;
- 7.1.3 албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, олгохоор амлах, бусдын эрхийг хязгаарлах;
- 7.1.4 төсвийн болон хандив, тусламжийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах;
- 7.1.5 албан үүргээ гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхгүй байхтай холбогдуулан бусдаас шан харамж шаардах;
- 7.1.6 албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх;
- 7.1.7 албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх;
- 7.1.8 үндэслэлгүйгээр хөрөнгөжих.

Тайлбар: Албан тушаалтан зургаан сарын албан тушаалын цалин хөлс, орлогоос илүү хөрөнгө, орлогыг хууль ёсны дагуу олсон болохыгоо үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй тохиолдолд **үндэслэлгүйгээр хөрөнгөжих** гэж үзнэ.

НИЙТИЙН АЛБАНД НИЙТИЙН БОЛОН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫГ ЗОХИЦУУЛАХ, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН 15 ДУГААР ЗҮЙЛ.

Төлбөр авахтай холбогдсон хязгаарлалт

- 15.1. Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэсний төлөө **аливаа төлбөр** авахыг хориглоно.
- 15.2. Хууль тогтоомжоор болон Засгийн газар, орон нутгийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлбөр авахаар тогтоосон бол **нэмэлт төлбөр** авахыг хориглоно.

11 ДҮГЭЭР ЗҮЙЛ.

Албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалт

- 11.1 Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ **өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн** хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- 11.2 Албан тушаалтан өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй ашгийн төлөө үйл ажиллагаатай харилцааг дуусгавар болгосноос хойш хоёр жилийн хугацаанд тухайн этгээдтэй холбогдох захиргааны

шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

- 11.3 Албан тушаалтан тухайн албан тушаалд сонгогдох, **томилогдохоосоо өмнө** аж ахуйн нэгжийн удирдах, гүйцэтгэх, хяналтын байгууллагын гишүүн байсан бол нийтийн албанд орсон, эсхүл тухайн аж ахуйн нэгжтэй иргэний эрх зүйн аливаа харилцааг дуусгавар болгосноос хойш хоёр жилийн хугацаанд тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай холбогдох захиргааны шийдвэр гаргахыг хориглоно.
- 11.4 Энэ хуулийн 11.3-т заасан захиргааны шийдвэр гаргах хязгаарлалт нь төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн удирдах, гүйцэтгэх, хяналтын байгууллагын гишүүн байсан албан тушаалтанд хамаарахгүй.

12 ДУГААР ЗҮЙЛ.

Шийдвэр гаргахад нөлөөлөхийг хориглох

- 12.1 Албан тушаалтан өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, мөн эдгээрт бэлтгэхэд өөрийн албан тушаалын байдлаа ашиглан **аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.**

16 ДУГААР ЗҮЙЛ.

Бэлэг авахтай холбогдсон хязгаарлалт

- 16.1 Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан бусдаас бэлэг

шууд буюу шууд бусаар авахыг хориглоно.

- 16.2 Энэ хуулийн 16.1-д заасан хориглолтод албан тушаалтанд албан үүрэгтэй нь холбогдолгүй өгсөн бэлэг болон албан үүрэгтэй нь холбогдуулан дипломат журмаар өгсөн бэлэг хамаарахгүй.
- 16.4 Гэр бүлийн гишүүн болон төрөл, садангийн хүнээс бусад этгээдээс авсан нэг удаагийн бэлэг, үйлчилгээний **үнэ, хөлс** тухайн албан тушаалтны нэг сарын цалинтай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн, эсхүл нэг эх сурвалжаас нэг жилийн туршид хүлээн авсан бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс тухайн албан тушаалтны гурван сарын цалинтай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд уг албан тушаалтан энэ тухай эрх бүхий албан тушаалтанд 30 хоногийн дотор бичгээр мэдэгдэх үүрэгтэй.
- 16.5 Албан тушаалтны авсан бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс тухайн албан тушаалтны зургаан сарын цалингийн хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд түүнийг төрийн өмчид шилжүүлнэ.
- 16.6 Албан тушаалтан зургаан сарын цалингийн хэмжээнээс илүү гарсан бэлэг, үйлчилгээний үнэ, хөлсний зөрүүг өөрөө төлж тухайн бэлэг, үйлчилгээг хүлээн авч болно.
- 16.7 Албан тушаалтан бэлэг авахаас өмнөх хоёр жилийн хугацаанд бэлэг өгөгч этгээдтэй холбогдох захиргааны шийдвэр, удирдлага, хяналт, шалгалт, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах зэрэг албан үүрэг хэрэгжүүлсэн бол түүнийг тухайн бэлэг өгөгч этгээдээс албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан бэлэг авсанд тооцно.
- 16.8 Энэ хуулийн 16.4-т заасан этгээдээс бэлэг авсан бол албан тушаалтан тухайн этгээдтэй холбогдох захиргааны шийдвэр

гаргах, удирдах, хянах, шалгах, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах зэрэг албан үүргийг хоёр жилийн хугацаанд гүйцэтгэхгүй.

- 16.9 Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төрд ногдох хувийг эзэмшигчийн төлөөлөгч албан тушаалтан нь тухайн хуулийн этгээдэд ажиллах хугацаандаа, түүнчлэн албан үүргээ гүйцэтгэж дууссанаас хойш хоёр жилийн хугацаанд тухайн хуулийн этгээд, түүний удирдлагын гишүүдээс бэлэг авахыг хориглоно.
- 16.10 Албан тушаалтны төрийн өмчлөлд шилжүүлсэн бэлэг, үйлчилгээний үнэ, хөлсийг үнэлэх, хадгалах, зарцуулах журмыг Засгийн газар батална.
- 16.11 Мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх шагналыг энэ хуулийн 16.1-16.10-т заасан журмаар зохицуулна.

17 ДУГААР ЗҮЙЛ.

Хандив авахтай холбогдсон хязгаарлалт

- 17.1 Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан **иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно.**
- 17.2 Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага албан үүрэгтэй нь холбогдолгүй гуравдагч этгээдээс үзүүлж байгаа нийтийн албаны хэрэгцээнд, ажилтны сургалт, үйл ажиллагааны зохион байгуулалт, техникийн дэмжлэг зэрэг албан тушаалтныг ашиг сонирхлын зөрчилд оруулахгүй хандив, бусад

санхүүгийн туслалцааг энэ хуулийн 17.1-д заасан хязгаарлалтад хамаарахгүй бол авч болно.

- 17.3 Албан тушаалтан хандив, санхүүгийн туслалцааг авахын өмнө өөрийн удирдлага, эсхүл эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан байна.
- 17.4 Энэ хуулийн 17.2-т заасан хандив, санхүүгийн туслалцаа авсан албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага хоёр жилийн хугацаанд хандивлагчтай холбоотой аливаа шийдвэр гаргахыг хориглоно.
- 17.5 Албан тушаалтан дараахь тохиолдолд биечлэн, эсхүл бусад этгээдээр зуучлуулан хандив хүсэх, хандив цуглуулахад оролцох, хүлээн авахыг хориглоно:
- 17.5.1. хүнд өвчнийг эмчлэхэд шаардлагатайгаас бусад тохиолдолд өөртөө буюу өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хэрэгцээнд;
- 17.5.2. өөрөө болон өөртэй нь хамаарал бүхий этгээд нь ашиг хуваалцдаг иргэн болон хуулийн этгээдийн хэрэгцээнд;
- 17.5.3. өөртэй нь хамаарал бүхий этгээд нь удирдлага, хяналт, захиргааны албанд нь ажилладаг хуулийн этгээдийн хэрэгцээнд.

18 ДУГААР ЗҮЙЛ.

Давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалт

- 18.1. Албан тушаалтан энэ хуулиар зөвшөөрснөөс өөр ажил, албан тушаал давхар эрхлэхийг хориглоно.
- 18.2. Улсын Их Хурлын болон Засгийн газрын

- гишүүн дараахь ажил, албан тушаалыг давхар эрхэлж болно:
- 18.2.1.хууль болон олон улсын гэрээгээр зөвшөөрсөн ажил;
 - 18.2.2.нийтэд тустай үйл ажиллагаанд чиглэсэн ажил;
 - 18.2.3.багшлах, эрдэм шинжилгээний болон бүтээлч ажил;
 - 18.2.4.хуульд заасан бол өөр өөрийн чиг үүргийн дагуу Улсын Их Хурлын болон Засгийн газрын албан тушаал;
 - 18.2.5.хууль тогтоомжоор зөвшөөрсөн олон улсын байгууллага дахь албан тушаал.
- 18.3. Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, мөрдөх албаны албан тушаалтан салбарын хуульд тусгайлан зааснаас бусад ажил, албан тушаал эрхлэхийг хориглоно.
- 18.4. Зэвсэгт хүчний албан тушаалтан өөрийн удирдах албан тушаалтны бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх гэрээгээр ажил гүйцэтгэж, эрх эдэлж болно.
- 18.5. Энэ хуулийн 18.2-18.4-т зааснаас бусад албан тушаалтан дараахь ажлыг давхар эрхэлж болно.
- 18.5.1.хууль тогтоомж, олон улсын гэрээгээр болон Засгийн газраас баталсан журмаар зөвшөөрсөн ажил;
 - 18.5.2.багшлах, эрдэм шинжилгээний болон бүтээлч ажил;
 - 18.5.3.ашиг сонирхлын зөрчил үүсэхээргүй бол өөрийн удирдах албан тушаалтан, эрх бүхий байгууллагын бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр бусад алба, гэрээний ажил, үүрэг.
- 18.6. Татварын албандажил, үйлчилгээхувиараа эрхэлж байгаа гэж бүртгүүлсэн, жилийн орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний

доод хэмжээг 80 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс илүүгүй, эсхүл төмс, хүнсний ногооны тариалан болон ойн аж ахуй, зөгий, загас, амьтан үржүүлэг, сургалт-аялал, сургалтын бусад үйл ажиллагаанаас орлого олдог бол албан тушаалтан үүнийгээ давхар эрхэлж болно.

20 ДУГААР ЗҮЙЛ.

Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон хориглолт

- 20.1. Хуульд өөрөөр заагаагүй бол албан тушаалтан энэ хуулийн 18.6-д зааснаас бусад **аж ахуйн үйл ажиллагаа гардан эрхлэх болон аж ахуйн нэгжийн удирдах бүтцэд ажиллахыг хориглоно.**
- 20.2. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын дээд шүүхийн шүүгч, Улсын ерөнхий прокурор, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит компани, олон улсын байгууллагын дарга, захирлын албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд нээлттэй тендер шалгаруулалтаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд төрийн болон орон нутгийн хэрэгцээнд бараа, ажил, үйлчилгээ худалдан авагч, төрийн санхүүгийн нөөц

бүрдүүлэгч, төрөөс баталгаа гаргасан зээл хүртэгч аж ахуйн нэгжийн хувь, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч байж болохгүй.

- 20.3. Энэ хуулийн 20.2-т заасан албан тушаалтан, түүнтэй хамаарал бүхий этгээд энэ зүйлд заасан үүргийг нийтийн албанаас чөлөөлөгдсөний дараа хоёр жилийн хугацаанд мөн биелүүлнэ.
- 20.4. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтан тухайн хуулийн этгээдэд нийлүүлэх төрийн болон орон нутгийн хэрэгцээний бараа, ажил, үйлчилгээ худалдан авах захиалгын нийлүүлэгчээс ашиг авахыг хориглоно.
- 20.5. Албан тушаалтан **нийтийн албанаас чөлөөлөгдсөнөөс хойш хоёр жилийн хугацаанд** албан үүргээ гүйцэтгэж байх хугацаандаа төрийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, улсын болон орон нутгийн нөөцийн хуваарилалт, удирдах, хянах, хариуцлага хүлээлгэх зэрэг асуудлаар шийдвэр гаргаж байсан аж ахуйн нэгжийн хувь, хөрөнгө эзэмшигч, хамтрагч болох, тус аж ахуйн нэгжээс хөрөнгө шилжүүлж авахыг хориглоно.

21 ДҮГЭЭР ЗҮЙЛ.

Албан тушаалаас чөлөөлөгдсөний дараахь хязгаарлалт

- 21.1. Албан тушаалтан нь албан үүргээс чөлөөлөгдсөнөөс хойш хоёр жилийн хугацаанд ашиг сонирхлын зөрчил үүсч болох дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:
- 21.1.1. урьд гүйцэтгэж байсан албан

үүрэгтэй нь холбоотой байсан аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах;

21.1.2. урьд ажиллаж байсан байгууллагатай гэрээ, контракт байгуулах, тухайн байгууллагаас олгодог зөвшөөрлийг хүсэх;

21.1.3. урьд ажиллаж байсан байгууллагын өмнө аливаа хувь хүн, хуулийн этгээдийг төлөөлөх.

21.2. Энэ хуулийн 21.1.2-т заасан хязгаарлалт нь тухайн этгээд албан тушаалд сонгогдож, томилогдохоос өмнө байгуулагдсан буюу сунгагдсан гэрээ, контракт, түүнчлэн нээлттэй тендер шалгаруулалтын дагуу байгуулагдсан, эсхүл жилийн орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс бага үнийн дүн бүхий гэрээ, контрактад хамаарахгүй.

21.3. Албан тушаалтан энэ хуулийн 21.1-д заасан хязгаарлалтад хамаарах этгээдтэй албаны чиг үүргийн дагуу харилцаа тогтоохыг хориглоно.

21.4. Албан тушаалтан энэ хуулийн 21.1-д заасан хязгаарлалт зөрчигдөж байгаа талаар эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.



ЗӨВЛӨМЖ

4

Нийтийн албан тушаалтанд хууль бус хүсэлт тавих, зохисгүй нөлөөлөл үзүүлэх, хээл хахууль санал болгох нь Танай байгууллагад хариуцлага хүлээлгэх үндэслэл болдог. Иймд бизнесийн үйл ажиллагаандаа зохисгүй харилцаа үүсгэхгүй байх талаар ажилтнууддаа зааж зөвлөж байх хэрэгтэй.

Төрийн албан хаагч өөрт нь ирж буй хууль бус аливаа нөлөөлөл, ашиг сонирхлын зөрчил, мөн олж мэдсэн авлигын шинжтэй үйлдлийг тухай бүр, цаг алдалгүй мэдэгдэх үүрэгтэй байдаг. Тиймээс давуу байдал олж авах, шударга өрсөлдөөнийг хязгаарлах авлигын шинжтэй аливаа хүсэлт, саналыг бизнес эрхлэгч санамсаргүйгээр, эсхүл мэдсээр байж гаргахгүй байх нь чухал. Эдгээрийг мэдэж байснаар хэрэг, зөрчилд холбогдохоос өөрийгөө болон төрийн албан хаагчийг урьдчилан сэргийлнэ.

Нөгөөтэйгүүр 2017 онд шинэчлэн найруулсан


Эрүүгийн хуульд авлигын гэмт хэргийг материаллаг бүрэлдэхүүнтэй байсныг хэлбэрийн бүрэлдэхүүнтэй болгож, зарим гэмт хэргийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсан. Энэ нь уг гэмт хэрэгт заавал эд хөрөнгийн хохирол учирсан байхыг шаардахгүй бөгөөд тухайн хууль бус үйлдэл, эс үйлдэхгүй гэмт хэрэгт тооцохоор болж байгаа юм. Түүнчлэн өмнө нь зөвхөн **хээл хахууль өгсөн** үйлдлийг гэмт хэрэг гэж үзэж байсан бол хуулийн өөрчлөлтөөр хахууль өгөхийг **амласан, санал болгосныг** гэмт хэрэгт тооцож хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан.

НИЙТИЙН АЛБАНД НИЙТИЙН БОЛОН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫГ ЗОХИЦУУЛАХ, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ 9 ДҮГЭЭР ЗҮЙЛ

Албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдлыг мэдэгдэх

- 9.1 Албан тушаалтан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар өөрийн удирдах албан тушаалтан, эсхүл эрх бүхий байгууллагад, хуулийн хариуцлага хүлээхээр бол **Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.**
- 9.2 Албан тушаалтан албан үүрэгтэй нь холбогдуулан аливаа этгээд бэлэг, үйлчилгээ, ашигтай нөхцөл байдлыг санал болгосон тохиолдолд дараахь арга хэмжээг авна:
- 9.2.1 саналаас татгалзах;
- 9.2.2 санал тавьсан этгээдийг тодорхойлох;
- 9.2.3 тодорхой нөхцөл байдлын улмаас бэлгийг эргүүлэн өгөх боломжгүй бол бэлгийг хадгалах ба энэ тухай өөрийн удирдах албан тушаалтан, эрх бүхий байгууллагад нэн даруй мэдэгдэх;
- 9.2.4 боломжтой бол тухайн үйл явдлын гэрчийг тэмдэглэх;
- 9.2.5 болсон нөхцөл байдлын талаарх мэдэгдлээ боломжит хугацааны дотор өөрийн удирдах албан тушаалтан, эрх бүхий байгууллагад бичгээр хүргүүлэх;

- 9.2.6 хариуцлага хүлээхээр зөрчил илэрсэн тохиолдолд эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх.



ЗӨВЛӨМЖ

5

Хээл хахууль авах гэмт хэрэг нь зөвхөн нийтийн албан тушаалтанд хамаарч байсан бол **хувийн хэвшлийн байгууллагын ажилтанд ч мөн хамаарах болсон**. Өөрөөр хэлбэл ажил, үүргээ хэрэгжүүлсний хариуд, эсхүл хэрэгжүүлэхийн тулд шууд, эсхүл бусдаар дамжуулан хахууль өгөхийг шаардсан, авсан бол авлигын хэрэгт шалгагдахаар болсныг Танай компанийн ажилтнууд ойлгож, мэдсэн болов уу? Ажилтнуудаа чадавхжуулах, сургалтын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх нь болзошгүй эрсдлээс хамгаална.



Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт 11 төрлийн үйлдлийг авлигын гэмт хэрэгт тооцохоор заасан. Бизнес эрхлэгч, хуулийн этгээд нь эдгээр гэмт хэрэгт холбогдохгүй байхын тулд хуулийн дараахь зүйл заалтыг сайтар мэдэж байх учиртай. Юуны өмнө хахууль авах гэмт хэрэгт төрийн албан хаагчаас гадна хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагын шийдвэр гаргах эрх бүхий ажилтан, албан хаагч мөн адил хамаарах болсныг анхаарна уу.

ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН

22.4 ДҮГЭЭР ЗҮЙЛ

Хахууль авах

1. Хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албаны чиг үүргээ хэрэгжүүлсний хариуд, эсхүл хэрэгжүүлэхийн тулд шууд, эсхүл бусдаар дамжуулан хахууль өгөхийг **шаардсан, авсан** бол нийтийн албанд томилогдох эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
3. Хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албаны чиг үүргээ хэрэгжүүлээгүйн хариуд, эсхүл хэрэгжүүлэхгүй байхын тулд, эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийсэн, эсхүл хийхийн тулд шууд, эсхүл бусдаар дамжуулан хахууль өгөхийг **шаардсан, авсан бол** нийтийн албанд томилогдох эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.



ЗӨВЛӨМЖ

6

Аль нэг ажилтны “болгоомжгүй” үйлдэл танай нийт бизнесийн үйл ажиллагааг **эрсдэлд оруулж болзошгүй** тул авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулж, компанийн удирдлагаас авлигын эсрэг баримтлах бодлого, чиглэлийг танилцуулж, ажилтнуудад ажил үүргээ гүйцэтгэхдээ **мөрдөх ёс зүйн зарчим, хүлээлгэх хариуцлагыг тодорхой, ойлгомжтой болгож өгөх** нь чухал.

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд хориглосон бэлэг, хандив зэрэг нь хуульд нийцээгүй бөгөөд гэмт хэргийн шинж агуулсан бол хахуульд тооцогдож болзошгүй. Тийм учраас санаатай болон санамсаргүйгээр албан үүрэгтэй нь холбогдуулан **аливаа бэлэг, урамшуулал, хөнгөлөлт урамшууллыг амлах, санал болгох, эсхүл төрийн албан хаагчийн хүссэн, шаардсан** тохиолдолд дээрх хууль тогтоомжид нийцэх эсэхийг нягталж байх нь зүйтэй юм.

Хахууль өгөх гэмт хэргийг компанийн удирдлага, эсхүл ажилтан үйлдсэн бол тухайн хүн хариуцлага хүлээхээс гадна хуулийн этгээдэд давхар эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Эрүүгийн хуульд өөрчлөлт орсон байна. Өөрөөр хэлбэл, компанийн ажлыг хийхдээ авлига, хээл хахууль өгөх зэрэг хууль бус аргаар “амжуулсан” ажилтныхаа бурууг компани хамт хүлээж, хариуцлага тооцуулах эрсдэлтэй болж байгаа юм. Иймээс ажилтнуудаа авлигаас урьдчилан сэргийлэх, сургах, эрсдлээс хамгаалах асуудалд анхаарал хандуулах шаардлагатай юм.

22.5 ДУГААР ЗҮЙЛ

Хахууль өгөх

1. Өөртөө, бусдад давуу байдал бий болгох зорилгоор бусдад албаны чиг үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдалтай нь холбогдуулан эд зүйл өгсөн, эдийн бус баялаг, тэдгээрийг өмчлөх эрхийг шилжүүлсэн, төлбөргүй, эсхүл хөнгөлөлттэй үйлчилгээ **үзүүлсэн**, эсхүл эдгээрийг **амласан, санал болгосон** бол нийтийн албанд томилогдох эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
3. Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

Тайлбар: -Хясан боогдуулсны улмаас аргагүй байдалд орж хахууль өгч, нийтийн албан тушаалтны хуулийн дагуу албаны чиг үүргээ гүйцэтгэж үзүүлэх төрийн үйлчилгээг авсан хүн энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн бол түүний авсан төрийн үйлчилгээг хэвээр үлдээж ялаас чөлөөлнө.

Хахууль авагчийг хууль бус үйлдэл хийлгэхээр урьдчилан төлөвлөж, зориуд санаатайгаар хахууль өгсөн хүнийг ялаас чөлөөлөхгүй. Хахууль өгсөн хүн энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн нь түүнд хүлээлгэх ялыг хөнгөрүүлэх үндэслэл болно.



ЗӨВЛӨМЖ

7

Хуулийн этгээдийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтан хувьдаа, бусдад давуу байдал тогтоох, ашиг хонжоо олох зорилгоор **албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласан нь** компанид хохирол учруулсан бол **авлигын хэрэгт хариуцлага хүлээх үндэслэл** болохоор хуульд өөрчлөлт орсон. Тийм учраас компанийн засаглалыг сайжруулж, **дотоод хяналтын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх** хэрэгтэй.



Эрүүгийн хуульд хуулийн этгээдийн эрх ашиг, өмч хөрөнгийг авлигаас хамгаалах зохицуулалт тусгасан. Өөрөөр хэлбэл, хувийн хэвшлийн хуулийн этгээдийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтан албаны эрх мэдлээ хувьдаа болон бусдад давуу байдал олгох, ашиг хонжоо олох зорилгоор урвуулан ашигласан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

22.12 ДУГААР ЗҮЙЛ

Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах

1. Хуулийн этгээдийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтан хувьдаа, бусдад давуу байдал тогтоох, ашиг хонжоо олох зорилгоор хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт, хэлцэл, дүрмээр олгогдсон албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласны улмаас үлэмж хэмжээний хохирол учруулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.



ЗӨВЛӨМЖ

8

Бизнесийн үйл ажиллагаанд бусад байгууллага, аж ахуйн нэгж, туслан гүйцэтгэгч нартай харилцах, гэрээ хэлэлцээр байгуулахдаа баримтлах **ёс зүйн дүрмийг тогтоон хэрэгжүүлэх**, мөн уг асуудлаар мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах, зөвлөгөө, мэдээлэл авч байх нь үр дүнтэй.

Бизнесийн үйл ажиллагааг ёс зүйтэй, авлигагүй явуулах, шударгаар өрсөлдөх тухай ойлголт, мэдлэг мэдээллийг компанийн хувьцаа эзэмшигч, эзэд, ажилтнуудын дунд түгээж, нэгдсэн ойлголт, стандартыг бий болгох нь компанийн засаглалын нэг чухал хэсэг юм. Энэ хүрээнд сургалт явуулах, авлигаас сэргийлэх дүрэм, журам, зохицуулалт бий болгож мөрдүүлэх, дотоод хяналтыг сайжруулах нь зүйтэй. Тухайлбал, төрийн албан хаагч болон харилцагч, хамтран ажиллаж буй бусад байгууллагын ажилтнуудад бэлэг сэлт, хандив,

урамшуулал өгөх нөхцөл, хэмжээ зэргийг хуульд нийцүүлэн байгууллагын дотооддоо журамлах, хандив, бэлэг сэлтийг бүртгэх, ил тод нээлттэй болгох, компанийн үйл ажиллагаанд гарч буй зүй бус зүйлсийн талаар мэдээлэл хүлээн авах арга журмыг тодорхойлох зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлэх боломжтой. Компани бүр өөрийн онцлогт тохирсон хэмжээнд өөрийн зохицуулалтыг хийж, ажилтнуудаас авлигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлдэг.

АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛИЙН

5 ДУГААР ЗҮЙЛ

- 5.1. Энэ хуулийн 3.1.5-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллага, иргэн дараахь нийтлэг үүрэг хүлээнэ:
- 5.1.1. Улсын Их Хуралд хэлэлцэгдэх хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн зүгээс саналаа илэрхийлэх бололцоо, нөхцөлөөр хангах;
 - 5.1.2. төрийн байгууллага авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаархи мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах;
 - 5.1.3. авлигын асуудлаар эрдэм шинжилгээний судалгаа хийх, ном, сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах зэрэг ажилд сургалт, эрдэм шинжилгээний болон төрийн бус байгууллагуудыг оролцуулах;
 - 5.1.4. сургалтын байгууллагууд эрх зүйн болон ёс зүйн хичээлийн хүрээнд суралцагчдад авлигын нийгмийн хор аюул, түүнээс урьдчилан сэргийлэх талаар зохих мэдлэг эзэмшүүлж, түүнийг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх;
 - 5.1.5. албан бус боловсролын байгууллага болон сургуулиас гадуурх сургалт эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэн өөрийн үйл ажиллагааны чиглэлийн дагуу авлигын нийгмийн хор аюулыг суралцагчдад тайлбарлан таниулах, түүнээс урьдчилан сэргийлэх талаар зохих мэдлэг эзэмшүүлэх;
 - 5.1.6. хэвлэл мэдээллийн байгууллага авлигын аливаа хэлбэрийг үл тэвчих нийгмийн сэтгэл зүйн орчинг төлөвшүүлэхэд нийтлэл, нэвтрүүлгийнхээ бодлогыг чиглүүлэх, энэ талаар байнга мэдээлэл, сурталчилгаа явуулах.

АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛИЙН 6 ДУГААР ЗҮЙЛ

6.5. Авлигаас урьдчилан сэргийлэх талаар аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан эрх, нийтлэг үүргээс гадна дараахь үүрэг хүлээнэ:

6.5.2. хувийн хэвшлийн байгууллага үйл ажиллагааныхаа ёс зүйн зарчмуудыг тогтоож, дагаж мөрдөх.

6.7. Төрийн байгууллага, албан тушаалтан авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзсэн тушаал, шийдвэр, журам, дүрмийг Авлигатай тэмцэх газраас өгсөн саналын дагуу дахин хянаж хүчингүй болгох буюу өөрчилнө.



ЗӨВЛӨМЖ

9

Авлигын аливаа тохиолдлыг мэдээлж хэвших нь чухал, түүнчлэн авлигыг үүсгэж буй төрийн байгууллагын хүнд суртал чирэгдэл, хууль бус дүрэм журмыг өөрчлөх талаар Авлигатай тэмцэх байгууллагад хандаж хамтран ажиллахыг зөвлөж байна.

Төрийн албан хаагч хахууль нэхсэн, бусад хувийн байгууллага, этгээдэд шударга бус давуу байдал олгосон гэх мэт авлига, ашиг сонирхлын зөрчлийн улмаас та, эсхүл танай бизнес хохирсон, эсхүл хохирох эрсдэлтэй бол гомдол, мэдээлэл өгөх нь бизнесийн орчныг шударга, цэвэр болгох хамгийн чухал алхам юм.

Түүнчлэн бизнесийн үйл ажиллагаанд саад, бэрхшээл болж буй хууль бус, хүнд суртал, шат дамжлага үндэслэлгүй үүсгэж буй тушаал шийдвэр, дүрэм, журмын талаар Авлигатай тэмцэх газарт мэдээлж, төрийн байгууллагын үйл ажиллагаанд дахь хүнд суртал, дутагдлыг арилгах, нээлттэй, ил тод байдлыг хангуулахад хамтран ажиллах боломжтой.

Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр сургалт, зөвлөгөө, мэдээлэл авах хүсэлтэй бол 70112465, 70112467 дугаарын утсаар Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй холбогдож болно.

Та авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар гомдол, мэдээлэл өгөх бол **Авлигатай тэмцэх газрын 110** дугаарт хандаж болох бөгөөд нэр, хаягаа нууцлах боломжтой. Харин таны мэдээлэл үнэн бодитой үндэслэлтэй байх ёстой. Таны гомдол, мэдээлэл ор үндэсгүй, эсхүл гүтгэлгийн шинжтэй бол шалгах боломжгүйг анхаарна уу.

АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛИЙН 9 ДҮГЭЭР ЗҮЙЛ

Өргөдөл, гомдол гаргах, мэдээлэл өгөх

9.1. Иргэн, хуулийн этгээд авлигын асуудлаар Авлигатай тэмцэх газарт өргөдөл, гомдол гаргаж, мэдээлэл өгч болно.

9.2. Авлигатай тэмцэх газар нь өргөдөл, гомдол, мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.





АВЛИГАТАЙ
ТЭМЦЭХ ГАЗАР

ШУДАРГА ЁС, ХӨГЖИЛ ДЭВШИЛД



ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ УТАС
/Төлбөр 0₮/





АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР
ШУДАРГА ЁС, ХӨГЖИЛ ДЭВШИЛД



Гомдол, мэдээлэл хүлээн авах утас
/Төлбөр 0₮/

Гомдол, мэдээллээ цахимаар өгөх бол
www.iaas.mn хаягаар хандана уу.